



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/146

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Монгол улсын хилийн тухай хуулийн 50.1.1, 50.1.2, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлиг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар тогтоолын тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Хил хамгаалалтад туслах хүчний зөвлөлийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх дэмжлэгт 40,000,00 (Дөчин сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 40,000,00 (Дөчин сая) төгрөгийг Засаг дарга дансны “Хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх” зардлаас гаргаж зарцуулахыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Батжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх зардлын худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог), зардлын гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Зөвлөлийн орлогч дарга, Хилийн 0257 дугаар ангийн захирагч (хурандаа У.Мөнхбат), Нарийн бичгийн дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (П.Ариунбат) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



ШИДЭРБАЯСГАЛАН